



## ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах өнгийн бугуйн зүүлт  
хэрэглэх журам

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/352 дугаар тушаалын 2.2, 4.11 дэх заалт, Байгууллагын дотоод журмын 3.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах өнгийн бугуйн зүүлт хэрэглэх журам"-ийг хавсралтаар баталсугай

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлзүй хариуцсан дэд захирал (Р.Гантуяа), Сувилахуй хариуцсан захирал (Г.Дэлхийцэцэг) болон нийт тасгийн эрхлэгч, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн (Б.Ганчимэг), Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба (Б.Бат-Оргил) нарт даалгасугай

ЗАХИРАЛ



ЭГ ГАЛБАДРАХ



## ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ӨНГИЙН БУГУЙН ЗҮҮЛТ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Эмнэлгийн хэрэглэж буй өнгийн бугуйвч нь хэвтэн эмчлүүлж буй өвчтөнийг танин тодорхойлоход зориулагдсан нэмэлт хэрэгсэл юм.

### 1. ЗОРИЛГО

Өвчтөнийг үнэлэлэн хэрэгцээ, хүсэлд тулгуурлан аюулгүй оновчтой тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд өнгөт бугуйвчны хэрэглээг стандартчилах замаар өвчтөний эрсдэлт хүчин зүйл, тусгай хэрэгцээ, мэдээлэлийг тодорхойлох юм.

### 2. АРГАЧЛАЛ

- 2.1 Өнгийн бугуйвчтай холбоотой төөрөгдлийн эрсдлийг бууруулах.
- 2.2 Өвчтөний аюулгүй байдлын эрсдэлийг тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд мэдээлэх
- 2.3 Харилцааны үйл явцад өвчтөн болон гэр бүлийн хүмүүсийг оролцуулж аюулгүй байдлыг дэмжих.
- 2.4 Эрсдэлийг бууруулах дараах стратегийг хэрэгжүүлэх
  - 2.4.1 Бугуйвчны зорилгыг тайлбарлахын тулд урьдчилан хэвлэсэн тайлбар бичвэрийг ашиглана. (жишээлбэл, "Харшил", "Унах эрсдэл" гм).
  - 2.4.2 Бугуйвч дээр гар бичмэл хэрэглэдэггүй.
  - 2.4.3 Өнгөт бугуйвчийг зөвхөн үнэлгээ хийлгэж буй сувилагч эсвэл тусгай зөвшөөрөлтэй ажилтан зүүж, тайлж болно.

### 3. Өнгөний тодорхойлолт

Дараахь хүснэгтэнд өнгөт тууз бүрийн утгыг харуулав.

Өнгө	Илэрхийлэлт
Улаан	Харшил (Эм тарианы, хүнсний, ургамлын, бусад харшил, асуумж)
Шар	Унах эрсдэл (MNS 6211:2019 "Унаж бэртэх эрсдэлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга"-с харах)
Ягаан	Эрчимт эмчилгээний болон амилахуйн тусламж авсан
Цагаан	Өвчтөнийг тодорхойлох таних мэдээлэл юм.(Хэвтэн эмчлүүлэх бүх өвчтөнд)
Ногоон	Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгч (Харааны сонсголын, хэл ярианы, тулгуур эрхтний бэрхшээлтэй )
Цэнхэр	Ижил нэртэй үйлчлүүлэгч (Эмчлүүлэгчийн нэр болон овог г.м)

### 4. Эмнэлгийн өнгөт бугуйвч зүүх

Өвчтөнд анхны үнэлгээ хийх үеэр мэдээлэл цуглуулж өвчтөний хэрэгцээг үнэлэн тодорхойлж, тухайн хүнд зориулсан тусламж үйлчилгээг эхлүүлнэ. Анхны болон дахин үнэлгээний үед "уналт", "харшил", бусад эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлно.

- 4.1 Анхан шатны үнэлгээгээр эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлсон аливаа өвчтөнд эмчийн заалтаар сувилагч, эсвэл тусгай зөвшөөрөлтэй мэргэжилтэн (сувилагч байхгүй үед) өвчтөнд өнгийн бугуйвчийг аль нэг мөчний хэсэгт зүүж өгнө. Үүнд: Хэвтэн эмчлүүлэх, амбулатори болон яаралтай тусламжийн тасгийн бүх өвчтөн багтана. Насанд хүрэгчдэд зүүн гарын бугуйн хэсэг, хүүхдэд зүүн хөлийн шилбэнд, амбулатори болон гэмтэлтэй мөчийн эсрэг талын мөчинд тус тус зүүнэ.

#### А. Амбулаторид:

1. Хэвтэн эмчлүүлэх шийдвэр гарч цахим бүртгэгч өвчний түүхийг нээж хэвлэсний дараа цагаан бугуйвчийг хэвлэн зүүж өгнө.

**Б. Яаралтай Тусламжийн Тасагт:**

1. Хэвтэн эмчлүүлэх шийдвэр гарч өвчний түүхийг нээж хэвлэсний дараа амилахуйн сувилагч цагаан бугуйвчийг хэвлэн зүүж өгнө.
2. ЭЭТасагт хэвтэн эмчлүүлэхээр бол ягаан өнгийн бугуйвчийг зүүж өгнө.

**В. Хэвтэн эмчлүүлэх тасагт:**

1. Дахин үнэлгээ хийх үед уналт, харшил, бусад эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж тохирох өнгийн бугуйвчийг нэмж зүүж өгнө.
2. Тасаг хооронд шилжиж буй өвчтөнд өөрийн тасгийн нэртэй цагаан бугуйвчийг зүүнэ

4.2 Эмнэлгийн дүрэм журмын дагуу өнгийн бугуйвч хэрэглэхийг сувилагч өвчний түүх болон холбогдох бүртгэлд (**Өвчтөн хүлээлцэх дэвтэр**) тэмдэглэнэ.

4.3 Өнгөт бугуйвчийг зүүсний дараа сувилагч өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүдэд бугуйвчийг салгаж болохгүй гэж зааварчилна.

4.4 Өнгийн бугуйвч гэмтсэн, унасан, хаягдаж гээгдсэн бол тохиолдолоор бүртгэн мэдээллэж нөхөн зүүж өгнө.

4.5 Ямар нэгэн өнгөт бугуйвчийг эмчилгээ эсвэл ажилбар хийхийн тулд тайлах шаардлагатай бол сувилагч нь бугуйвчийг авч дараа нь шинээр зүүж өгнө. Энэ нь сувилагч эрсдэлийг дахин баталгаажуулна.

4.6 Эмнэлгээс гарах үед өнгийн бугуйвчийг ээлжийн сувилагч авна.

**5. Өвчтөн болон гэр бүлийн оролцоо**

Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүдэд зүүж буй бугуйвч, түүний ач холбогдлын талаар мэдээлэл өгөх нь чухал юм.

5.1 Өвчтөн болон тэдний гэр бүлийн гишүүдэд өнгийн бугуйвч зүүхийг хүлээн зөвшөөрүүлэх нь чухал юм. Бугуйвчнуудыг өнгөөр ялгах үйл явц нь бугуйвч зүүх үед хэрхэн анхаарал тавьдаг, энэ нь аливаа мэдээллийн үүрэг зэрэг нийтлэг ойлголтыг баталгаажуулна.

5.2 Тиймээс, үнэлгээний явцад сувилагч өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүдэд бугуйвчийн ойлголт ач холбогдлын талаар сургах боломжийг ашиглана.

**6. Ажилтаны сургалт**

Шинэ болон давтан чиг баримжаа олгох сургалтын үеэр өнгөт бугуйвчны талаархи боловсролыг нийт ажилтнуудад олгоно.

**7. Өвчтөн татгалзах**

7.1 Хэрэв өвчтөн өнгөний бугуйвч зүүхээс татгалзвал эрсдэлийн өвчтөн, гэр бүлийнхэнд тайлбарлан өгнө.

7.2 Сувилагч өвчтөний болон түүний гэр бүлийн гишүүний татгалзсан хариу тайлбарыг эмчлэгч эмчид мэдэгдэнэ.

**ХОЛБООТОЙ ДҮРЭМ ЖУРАМ:**

1. "Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам" ЭМСайдын 2022 оны А/352 тоот тушаалын хавсралт
2. MNS 6211:2019 "Унаж бэртэх эрсдэлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга"
3. "Өвчтөнд түүний эрүүл мэндийн байдал болон эмчилгээний явцад гарч болох үр дүнг мэдээллэх журам" Захирлын 2022 оны А/67 тоот тушаалын хавсралт
4. "Унах эрсдэлээс сэргийлэх журам" Захирлын 2022 оны А/69 тоот тушаалын хавсралт
5. "Тохиолдол бүртгэх, мэдээллэх, хариу арга хэмжээ авах журам" ЭМСайдын 2024 оны А/112 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ХЯНАСАН:**
